



**НИЙСЛЭЛИЙН УЛААНБААТАР ХОТЫН
ШУУРХАЙ УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТЫН ТӨВ ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2018 оны 05 сарын 22 өдөр

Дугаар А/10

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 145 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын Шуурхай удирдлага, зохицуулалтын төв” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрмийн 4 дүгээр хэсгийн 4.9.9 дэх заалт, Хөдөлмөрийн дотоод журмын 11 дүгээр зүйлийн 11.1.2 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулах болон шуурхай ажиллагааны бэлэн байдал, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангуулах зорилгоор Техник хангамжийн хэсгийн инженерүүдэд ажлын зориулалтын хамгаалалттай гутал авахыг Системийн ахлах инженер /П.Батбилэг/-д үүрэг болгосугай.

2. Дээрх ажлын гутал авахад шаардагдах 255000 /хоёр зуун тавин таван мянган/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /М.Ичинхорлоо/-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ерөнхий диспетчер /Г.Ганзориг/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ч.ГАН-ОЧИР

